

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/18/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Утас: 70483413	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
2022 он	Утас: 70484030	Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Утас: 99177546	Аудитор: Б.Цэвэлмаа
	Утас: 99026016	Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	5
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	7
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Орлогын данс	11
3.5.2 Зардлын данс	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Э.ДАВААНЯМ
ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 192
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй


07020536

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		689,116.9	788,114.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	139,968.2	188,647.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	148,709.3	202,155.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	390,014.3	392,999.3
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	10,425.0	4,313.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,540,176.0	5,858,370.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,540,176.0	5,858,370.1
39200	Биет хөрөнгө		5,458,167.8	5,774,531.9
39300	Биет бус хөрөнгө	13	82,008.2	83,838.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,229,292.8	6,646,484.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		27,344.2	74,545.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	27,344.2	74,545.9
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	15,000.0
41300	Өглөг	17а, 17б	27,344.2	59,545.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,201,948.7	6,571,938.8
51	Засгийн газрын хувь оролцоо		6,201,948.7	6,571,938.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,266,859.9	1,266,859.9
51200	Хуримтлагдсан үр дүн		3,147,377.1	3,517,367.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,787,711.6	1,787,711.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,229,292.8	6,646,484.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,680,846.7	3,371,160.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		58,063.8	47,915.5
110	Орлогын албан татвар		52,894.9	43,660.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		52,894.9	43,660.8
113	Хөрөнгийн албан татвар		1,748.0	1,262.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		3,420.8	2,992.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	452,342.0	731,434.0
120	Нийтлэг татварын бус орлого		452,342.0	731,434.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,170,440.9	2,591,811.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,334,535.5	2,781,729.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,334,535.5	2,781,729.8

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,454,770.2	2,723,666.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,433,464.0	1,506,855.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		185,340.1	196,413.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		243,068.4	233,921.8
2104	Хангамж, бараа материалын зардал		100,162.7	152,315.7
2105	Нормативт зардал		67,530.2	282,302.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		18,552.6	11,139.0
2107	Томилолт, зочны зардал		4,167.4	5,308.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		42,481.6	53,382.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		360,003.2	282,027.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		879,765.3	58,063.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		346,311.2	589,430.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		179,200.2	215,898.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		167,111.0	373,532.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,522,690.6	2,831,040.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	58,063.8	47,915.5
110	Орлогын албан татвар	52,894.9	43,660.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	52,894.9	43,660.8
113	Хөрөнгийн албан татвар	1,748.0	1,262.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,420.8	2,992.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,183.0	1,796.6
1181	Газрын төлбөр	997.5	1,196.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	240.3	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	292,701.6	292,081.3
120	Нийтлэг татварын бус орлого	292,701.6	292,081.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,171,925.2	2,491,043.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,156,177.5	2,531,141.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,156,177.5	2,531,141.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,275,154.9	2,455,832.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,479,207.3	1,575,466.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,668.6	221,023.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	259,388.4	255,093.2
2104	Хангамж, бараа материалын зардал	175,998.0	181,082.2
2105	Нормативт зардал	49,566.8	135,036.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,569.1	19,704.5
2107	Томилолт, зочны зардал	4,167.4	5,308.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,241.0	43,220.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,348.3	19,897.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	881,022.6	75,309.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	366,513.1	299,898.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	215,591.5	266,219.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	215,591.5	266,219.6

2200	Дотоод эх үүсвэрээр	215,591.5	266,219.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-215,591.5	-266,219.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-92,500.0	15,000.0
14	Бусад эх үүсвэр	0.0	25,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	83,500.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,000.0	10,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	58,421.6	48,678.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,546.7	139,968.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	139,968.2	188,647.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,034,837.7	6,034,837.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,034,837.7	6,034,837.7
9	Тайлант үеийн үр дүн	167,111.0	167,111.0
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,201,948.7	6,201,948.7
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,201,948.7	6,201,948.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,542.2	-3,542.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,198,406.5	6,198,406.5
19	Тайлант үеийн үр дүн	373,532.3	373,532.3
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,571,938.8	6,571,938.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,574,646.90	2,414,134.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,247,204.00	2,200,649.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,210,380.90	2,164,233.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,498,586.70	1,480,459.95
210101	Үндсэн цалин	1,275,818.30	1,270,438.99
210102	Нэмэгдэл	64,500.00	62,251.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,500.00	4,029.00
210104	Урамшуулал	92,436.80	86,213.49
210105	Гэрээт ажлын хөлс	60,331.60	57,526.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,838.30	193,290.74
210201	Тэтгэврийн даатгал	137,170.50	139,537.62
210202	Тэтгэмжийн даатгал	14,966.40	11,498.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,992.20	11,871.08

210204	Ажилгүйдлийн даатгал	2,976.40	2,790.56
210205	Эрүүл мэндийн даатгал	29,732.80	27,592.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,261.80	234,665.77
210301	Гэрэл, цахилгаан	13,630.00	11,711.15
210302	Түлш, халаалт	221,221.80	220,585.11
210303	Цэвэр, бохир ус	2,410.00	2,369.52
2104	Хангамж, бараа материалын зардал	78,434.10	75,655.16
210401	Бичиг хэрэг	7,060.00	7,019.30
210402	Тээвэр, шатахуун	56,797.60	55,671.39
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,645.50	5,333.12
210404	Ном, хэвлэл	150.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,590.50	1,002.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,190.50	6,528.40
2105	Нормативт зардал	88,453.50	80,949.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,345.70	18,571.41
210502	Хоол, хүнс	51,487.80	50,257.28
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,620.00	12,121.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,393.90	62,387.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,128.90	46,536.60
210602	Тавилга	1,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240.00	230.00
210604	Урсгал засвар	15,625.00	15,620.50
2107	Томилолт, зочны зардал	7,480.00	4,961.80
210702	Дотоод албан томилолт	7,480.00	4,961.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,606.00	17,030.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,720.00	13,791.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,578.00	888.00
210803	Даатгалын үйлчилгээ	235.00	199.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	660.00	491.72
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	188.00	132.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240.00	848.00
210807	Газрын төлбөр	88.00	21.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	197.00	71.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700.00	586.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,326.60	14,832.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,976.40	11,488.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,350.20	3,344.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,823.10	36,415.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,823.10	36,415.89
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,663.10	23,317.09
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,160.00	13,098.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	260,242.90	213,485.09
223001	Бусад хөрөнгө	260,242.90	213,485.09
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	67,200.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	67,200.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,574,646.90	2,483,844.44
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,497,309.40	1,489,047.96
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,497,309.40	1,489,047.96
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	943,946.40	934,201.62
320001	Орон нутгийн төсвөөс	708,903.50	699,158.72
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	235,042.90	235,042.90

33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,291.10	4,228.81
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,291.10	4,228.81
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	111,100.00	56,366.05
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800.00	51,242.15
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,100.00	5,123.90
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	35,200.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.00	55,292.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.00	125,001.80

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,271.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,271.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,896.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,592.38
210101	Үндсэн цалин	22,413.27
210104	Урамшуулал	9,179.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,491.85
210201	Тэтгэврийн даатгал	4,491.85
2104	Хангамж, бараа материалын зардал	14,242.15
210401	Бичиг хэрэг	709.33
210402	Тээвэр, шатахуун	9,337.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56.00
210404	Ном, хэвлэл	2,222.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,917.30
2105	Нормативт зардал	54,086.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,258.38
210502	Хоол, хүнс	828.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,946.86
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,589.60
210604	Урсгал засвар	357.26
2107	Томилолт, зочны зардал	347.06
210702	Дотоод албан томилолт	347.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,124.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,124.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,065.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,265.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,375.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,375.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,375.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,007.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	152,007.32
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	257.26
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,434.17
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,000.40
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	85,315.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	736.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	736.10

1. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/81 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 3,334.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 66.7 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 2,781.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 55.6 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-ын 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.3 хувиар буюу 417.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 140.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 188.6 сая төгрөг болж, 48.6 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн 187.6 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 1.0 сая төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн 20.8 хувь болох 39.3 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 30.4 хувь болох 57.5 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд, 12 хувь болох 22.6 сая төгрөг нь Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн сангийн, 32.7 хувь болох 61.8 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 3.3 хувь болох 6.4 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 0.8 хувь болох 1.0 сая төгрөг нь "Эрдэнэ Эрчим хүч" ААТҮГ-ын дансанд байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 148.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 202.2 сая төгрөг болж, 53.5 сая төгрөгөөр өссөн. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 95.8 сая төгрөгийн, "Эрдэнэ Эрчим хүч" ААТҮГ-ын 2.4 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 103.9 сая төгрөгийн авлага байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн

нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Бараа материалын эхний үлдэгдэл 400.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 393.0 сая төгрөг болж, 3.0 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материал тайлант оны эцэст 393.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 1 хувь буюу 4.3 сая төгрөг нь орон нутаг хөгжлийн сангаас бэлтгэсэн өвс тэжээлийн нөөц байна. Тайлант онд бараа материал 554.0 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний 71.5 хувь буюу 396.2 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 25 хувь буюу 137.9 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 3.5 хувь буюу 19.9 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бол 557.1 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 397.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,249.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,815.8 сая төгрөг болж, 566.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 52.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 36.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, 506.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаар нийт 595.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 19.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 10.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн нийт 29.0 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 277.4 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 29.0 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 27.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 74.5 сая төгрөг болж, 47.2 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн 20.5 сая төгрөгийн, "Эрдэнэ Эрчим хүч" ААТҮГ-ын 38.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 13.5 сая төгрөгийн, ЗДТГ, ИТХ-ын 2.2 сая , төгрөгийн байгууллагад төлөх өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,201.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,571.9 сая төгрөг болж, 370.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт 3.5 сая төгрөгийг бүртгэж, хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,517.4 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 47.9 сая төгрөгийн татварын орлого, 292.1 сая төгрөгийн татварын бус орлого, 2,491.0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,831.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,781.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 216.0 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын "Сумын 2021 оны төсөв нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 05 дугаар тогтоолд зааснаар Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч

тайлант онд 46.8 сая төгрөгийн татварын орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 68.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 145 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс бууны албан татварын орлого тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 2,574.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,574.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,247.2 сая төгрөгийг урсгал зардалд, 260.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 67.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,497.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 708.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 235.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 22.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 35.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжих, 75.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,414.1 сая төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 21.1 сая төгрөгөөр давуулсан, нэгж байгууллагын төсвөөс 2.1 сая төгрөгийн зарцуулаагүй татан төвлөрүүлсэнтэй холбоотой.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 152.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.03 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан

төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 51.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 85.3 сая төгрөгийн орлогыг тайлагнан 0.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 151.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 20.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнө онуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаас Эрдэнэ сумын сургуулийн 27.3 сая төгрөгийн албан шаардлага биелэгдээгүй, хэрэгжих шатандаа байна. Тус сургууль нь Орон нутгийн өмчийн давхар бүртгэгдсэн хөрөнгийг хасах хүсэлтээ өгсөн, хурлын тогтоол нь гараагүй хүлээгдэж байна.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сан, 1 аж ахуйн тооцоот газар, нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 3 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 3 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 423.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 68.2 сая төгрөгийн алдааг залруулж 5.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 349.4 арилгах албан шаардлага хүргүүлж байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:

Аудитаар иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 0.1 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс бууны албан татварын орлого 0.5 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын "Сумын 2021 оны төсөв нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 05 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай

нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Эрдэнэ сумын ИТХ

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь татварын тодорхойлолтоос 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Эрдэнэ сумын Соёлын төв

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											

Төсвийн төвлөрүүлэн захирагч									
Эрдэнэ сумын Төвлөрүүлэн захирагч	1	0.5					1	0.5	
Түүвэрт хамрагдсан байгууллага									
Соёлын төв									
ИТХ							1	0.1	
Дүн	1	0.6					2	0.6	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал									
Төсвийн төвлөрүүлэн захирагч									
Дүн									
Соёлын төв							1		
ИТХ							1		
Дүн	1	0.1	1	0.1			2		
Нийт дүн	1	0.7	1	0.1			4	0.6	